

Үндэстэн дамнасан хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлье

Ц.Бумхорол,

*Стратегийн судалгааны хүрээлэнгийн Эдийн засаг нийгэм
судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтан*

Хүний аюулгүй байдал хангагдахын нэг гол үндсэн зарчим бол айх аюулгүй амьдрах явдал юм. Ингэж амьдрахын тулгуур нөхцөл нь дутагдаж гачигдахын зовлонгүй байхад оршино. Тэгвэл өнөөдөр манайд, бидний цөөхөн монголчуудын аюулгүй байдал хэрхэн хангагдаж байна вэ? Ядуурал, ажилгүйдэл гээд нийгмийн тулгамдсан, шийдвэрлэгдэж чадаагүй асуудлууд байхын зэрэгцээ бидний тэр бүр дуулж сонсож байгаагүй хачин гэмээр үзэгдлүүд гарсаар байна. Цөөхөн монголчуудын маань зарим нэг хэсэг нь үндэстэн дамнасан гэмт хэрэг болох хүн худалдаалах, хар тамхи худалдан борлуулах, эрдэнэт хүнийг хил дамжуулан худалдахад зуучлах зэрэг гэмт хэрэгт өртөж, зарим нь золиос болж, энэ тухай баримтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацсаар байна.

Адгуулж хариулж байдаг малаа харийн хүнд худалдахдаа хүртэл ёс төртэй ханддаг монголчууд биднээс Монгол хүний аюулгүй байдлыг хангах, бүр цаашилбал хүн амын удмын сангаа цэвэр ариун хадгалж хамгаалахын тулд хүн амаа олон улсын үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хувь хүнийг өөрөө өөрийгөө хамгаалах дадал хэвшилд сургах, хохирсон хүмүүсийг хамгаалах, тэднийг нөхөн сэргээж, хэвийн амьдралд татан оруулах гээд шинэ арга барил, шинэ ажил үйлчилгээ, шинэ мэргэжил, шинэ тогтолцоог зайлшгүй шаардаж байна.

Энэхүү илтгэлд хүн худалдаалах гэмт хэрэг гэж юу болох, нөлөөлдөг хүчин зүйл, энэхүү гэмт хэргийн нөхцөл байдал манай улсад ямар байгаа, түүний шалтгаан үр дагавар, Монгол Улсын төр, засгаас хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хууль эрхзүйн орчин, цаашид анхаарах тулгамдсан асуудлуудыг тодорхойлохыг зорьлоо.

Хүн худалдаалах гэмт хэрэг, түүнд нөлөөлдөг хүчин зүйл, шалтгаан, үр дагавар - Дэлхийн чиг хандлага

Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай, олон улсын шинж чанартай гэмт хэргийн төрлүүд дотроос хүн худалдаалах гэмт хэрэг улс орнуудын төдийгүй олон улсын байгууллагуудын анхаарлыг татаж, дэлхий нийтээр энэ гэмт хэргийн эсрэг тэмцэх, шийдвэрлэх арга замын талаар удаа дараа хэлэлцсээр байна. Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд энэ асуудлын суурь үндэс, шалтгаан үр дагавар, нөхцөл байдлыг сайтар ойлгох нь юу юунаас илүү чухал юм. Дэлхийн хэмжээнд олон зуун айл өрх, хувь хүмүүсийн сэтгэлийг түгшээж байдаг энэхүү гэмт хэргийн талаар зөв ойлголт төсөөлөлтэй болсны үндсэн дээр түүнтэй хэрхэн тэмцэх,

хувь хүнийг өөрийгөө хамгаалах чадвартай болгох, нийгмийн сэтгэл зүйд зөв ойлголт өгч төлөвшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах зэрэг олон асуудлууд ар араасаа ундрэн гарч байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг гэж юу вэ? Хүн худалдаалахтай холбогдсон нөхцөл байдлыг Палермогийн протоколд⁸ тодорхойлсон байдаг. Уг протоколын дагуу “Хүн худалдаалах” гэдэгт хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсвэл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсвэл өөр этгээдийг эрхэндээ байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх буюу ашиг олох зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх,

дамжуулах, нуух буюу хүлээж авах үйлдлийг ойлгодог⁹.

Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолтыг зорилго, үйлдэл, арга хэрэгслээр нь 3 үндсэн бүлэгт хуваан авч үзэж, бүх илрэлийг энэ гэмт хэрэгт хамруулдаг. Хүнийг мөлжих зорилгоор гэдэгт биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харьцаанд хүчээр оруулан мөлжих, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил хэрэглэх, эрх чөлөөгүй байлгах, эд эрхтнийг нь авах зэрэг үйлдлүүдийг “хүн худалдаалах гэмт хэрэг”-т хамруулан авч үздэг. Мөлжих зорилгоор хүнийг, ялангуяа эмэгтэйчүүд, охидыг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуух буюу хүлээж авах зэрэг үйлдэл, үйл явцыг мөн хүн худалдаалах гэж үздэг. Хүн худалдаалах гэмт хэргийн арга хэрэгсэлд хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсвэл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсвэл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх буюу ашиг олох зэрэг хамрагддаг.

АНУ-ын Төрийн Департаментаас 2010 онд хэвлэн гаргасан хүн худалдаалах тухай тайланд “хүн худалдаалах гэмт хэрэг” гэдгийг “хүчээр үйлчилгээ үзүүлүүлэх зорилгоор хүн хүлээн авдаг этгээд, эсвэл хүнийг өөрийн мэдэлд байлгадаг үйл ажиллагаа” гэсэн товч тодорхойлолтыг өгчээ. Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүчээр хөдөлмөр хийлгэх, бэлгийн харьцаанд хүчээр оруулах зорилгоор хүн худалдаалах, гадаадаас ирж ажиллагчдыг боолын хөдөлмөр эрхлүүлэх, эрхшээлдээ оруулах, хүүхдийг хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, хүүхдийг цэрэгт явуулах, хүүхдийг бэлгийн харьцаанд хүчээр оруулах зорилгоор худалдаалах зэрэг янз бүрийн хэлбэртэй байна. Дэлхийн хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн ихэнх хувийг

хүчээр хөдөлмөр эрхлүүлэх хэлбэр эзэлж байна. Хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж байгаа 10 хүн дутмын нэг нь хүчээр биеэ үнэлж, хохирогч болж байхад 9 нь хүчээр хөдөлмөр эрхэлдэг гэсэн тооцоог Олон улсын хөдөлмөрийн байгууллага гаргасан байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг гарахад нийгэм, эдийн засаг, улс төрийн гэсэн гурван үндсэн хүчин зүйл нөлөөлдөг байна¹⁰. Нийгмийн хүчин зүйлд эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засагт эзлэх байр суурь, мэдээллийн хүртээмж хангалттай бус, гэр бүлийн доторх уур амьсгал, бэлгийн мөлжлөг дарамт шахалт, хүйсийн болон үндэстний цөөнх, уугуул хүн амыг ялгаварлан гадуурхах үзэл, нийгмийн эмзэг бүлэгт хамрагдагчдын хууль эрх зүйн мэдлэг, хамгаалах тогтолцоо сул, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хууль бус зар сурталчилгаа явуулах, түүнийг зохицуулах бодлого сул зэрэг асуудлууд хамрагдана. Эдийн засгийн хүчин зүйлд хувь хүний болон гэр бүлийн гишүүдийн бусдад тавьсан өр зээлийн асуудал, ядуу буурай орон, тэдгээрийн хүн амын ядуу, эмзэг хэсгийн дундах хүнс тэжээлийн хомсдолтой байдал, эдийн засгийн болон орлогын тэгш бус байдал, эдийн засгийн хямралт байдал багтдаг. Улс төрийн хүчин зүйлд тухайн улс орны хууль эрх зүйн тогтолцоо, хуулиудын хэрэгжилтийн байдал, хилийн шалган нэвтрүүлэх ажиллагааны үнэн зөв, шударга, авилгаас ангид явуулж буй үйл ажиллагаа, цагаач иргэдийн талаарх төрийн бодлого, зохицуулалт зэргийг авч үздэг.

Хүн худалдаалах гэмт хэрэгт нөлөөлөх бас нэг хүчин зүйл нь гадаад, дотоод үрчлэлт, тухайн улсын эмэгтэйчүүдийн гадаадын иргэдтэй гэр бүл болох асуудал юм. Гэрлэлтийг бодитой болон хуурамч гэсэн 2 төрөлд ангилан авч үздэг. Сайн дурын үндсэн дээр бүртгэгддэг гэрлэлтийг бодитой гэрлэлт гэж үздэг байхад хуурамчаар гэрлэх явдал нилээд нийтлэг болж байна. Хуурамч гэрлэлтэд нэг талаас тухайн улс оронд очиж амьдрах, байнгын оршин суух

⁸ Энэхүү протоколыг хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилготой 2000 оны 11 дүгээр сард Итали улсын Палермо хотод зохион байгуулагдсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцийн бага хуралд оролцогч улс орнууд санаачлан үзэглэсэн билээ.

⁹ БСШУЯ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Хүний аюулгүй байдлын судалгааны төв /ТББ/ “Хүн худалдаалах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх нь” “Их, дээд сургуулиудад заах хичээлийн гарын авлага” Улаанбаатар 2009

¹⁰ Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн, докторант П.Оюунчимэг “Эмэгтэйчүүд, охидыг хил дамнуулан наймаалах гэмт хэргийн талаарх ойлголт, нөлөөлөх хүчин зүйлсийн талаар” Хүний эрхийн Үндэсний комисс, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь” илтгэлийн эмхтгэл Говийн бүсийн сургалт, зөвлөлгөөн Дорноговь аймаг, Замын-Үүд сум 2009 оны 5 сарын 7, 8 өдөр

визтэй болох сонирхол, хөрөнгө санхүүгийн асуудлаа шийдвэрлэх, гэр бүлийн болон бусад дарамт шахалтаас зугатах зэрэг асуудлууд нөлөөлж байхад нөгөө талаас хууран мэхлэх арга хэрэглэн өөрийн эх орондоо аваачин хүний наймааны золиос болгох, бэлгийн болон бусад дарамтад байлган ашиг олох зэрэг сонирхол давамгайлдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь тогтвортой, нэг байрандаа байгаад байдаг үйлдэл биш гэдгийг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Хуулийн орчинг байнга эргэн харах, улс орнууд энэ гэмт хэргийн чиглэлээр хамран ажиллах хэм хэмжээ, тогтолцоонд үндсэндээ шилжээд байна.

Палермогийн буюу “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцид хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх, ингэхдээ эмэгтэйчүүд ба хүүхдийн хувьд тусгайлан анхаарал тавих, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын эрхийг бүрэн хүндлэн тэднийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, хамтын ажиллагааг дэмжих гэсэн зарчмыг тодорхойлжээ¹¹. Уг конвенцид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх, энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан зааж өгснөөс гадна энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулалтын хэм хэмжээг тогтоож өгсөн.

Хүн худалдаалах гэмт хэргийн Монгол Улс дахь нөхцөл байдал, түүний хууль эрхзүйн орчин

АНУ-ын Төрийн Департаментаас 2010 онд эрхлэн гаргасан Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх тайланд дэлхийн хэмжээнд нийт 12,3 сая хүн хөлсний хөдөлмөр түүний дотор хөлсгүй боолын хөдөлмөр, хүчээр биеийг нь үнэлүүлэх зэрэг гэмт хэргийн золиос болж буйг дурджээ. Дэлхийн хэмжээнд 1000 оршин суугчид хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 1,8 хүн ногдож байхад

Ази тивд энэ тоо 3 байгаа нь энэ бүс нутагт ийм төрлийн гэмт хэргийн тохиолдол өндөр байгааг нотолж байна. Хүн худалдаалах гэмт хэргийн 4166 тохиолдлыг 2009 онд амжилттай шийдвэрлэсэн болохыг тайланд дурджээ¹².

Орчин үед эмэгтэйчүүд, хүүхдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор, эрэгтэйчүүд, хөвгүүдийг бусад зорилгоор худалдаалах гэмт хэрэг ихээр үйлдэгдэж, гэмт хэргийн бүтцэд тэдгээрийн эзлэх хувийн жин тогтмол өсөж байна. Хүүхдийг хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртүүлэх зорилгоор урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах/ орогнуулах, хүлээж авах үйлдлийг “хүн худалдах” гэж үздэг. Хүнийг ихэвчлэн гадаад улс орнууд руу гаргаж худалдахын зэрэгцээ улс орон дотор хүн худалдах гэмт хэрэг ч үйлдэгддэг¹³.

Хүн худалдаалах гэмт хэрэг хэдийнээс манайд бий болж вэ гэдгийг судалж үзвэл бүр анх 2000 онд Югославын иргэн Максим гэгч монгол охидыг барууны орнуудад худалдаалсан болох нь тогтоогдож, ял шийтгэл хүлээсэн бол, үүний дараа 2001 онд хүн худалдаалах гэмт хэрэг манай улсад хоёр удаа гарч, албан ёсоор бүртгэгдсэнээр энэ гэмт хэрэг бодит үйлдэл болжээ¹⁴.

Хүн худалдаалах гэмт хэрэгт эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүд өртөж байгаа бөгөөд тэднийг гол төлөв хүчээр биеийг нь үнэлүүлэх, боолын хөдөлмөр эрхлүүлж байгаа нь судалгаагаар тогтоогдсон байна¹⁵. Иймнөхцөлд байгаа монгол эрэгтэй, эмэгтэйчүүдийг Хятад, Макао, Малайз, Өмнөд Солонгос, Гонгконгоос олж болно. Түүнчлэн Турк, Казахстан, Чехийн Бүгд Найрамдах Улсад Монгол эрэгтэй, эмэгтэйчүүд боолын хөдөлмөр эрхэлж байна. Монголчууд Турк улсад визгүй зорчдогийн сөрөг дагавар нь тэнд ажиллахаар очиж буй олон тооны хүмүүс боолын болон хүчээр биеийг нь үнэлүүлэх үйлдэлд өртөж, энэ тоо өсөн нэмэгдсээр байна. Дотоодод ч байдал төдийлэн таатай биш байна. Монгол хүүхдүүд барилга, уул уурхай, аж үйлдвэрийн салбарт биеийн хүчний ажил хийж, гэмтэл

¹¹ НХХЯ, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургууль, НҮБ-ын Хүүхдийн сан “Хүн худалдаалах гэмт хэрэг” Суралцагсдын гарын авлага, Улаанбаатар хот, 2009

¹² Trafficking in persons Report 2010, Office to Monitor and Combat Trafficking in Persons

¹³ Б.Уранцэцэг “Хүн худалдаалах гэмт хэргийн талаархи нийгмийн ойлголт, хандлага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс “Хүний эрх” улирал тутмын сэтгүүл 2009/2

¹⁴ Т.Цогзолмаа “Югославын иргэн манайд анх хүн худалдаалах гэмт хэргээр шийтгэгдсэн” Үндэсний шуудан, 2010, 8, 10 №189 /903/

¹⁵ Trafficking in Persons Report 2010

бэртэл авч, эрүүл мэндийн хувьд хохирсоор байна. Монголын эмэгтэйчүүд зуучлалын үйлчилгээгээр дамжуулан гол төлөв Өмнөд Солонгосын эрчүүдтэй хуурамчаар гэрлэж, улмаар гэрийн хорионд орох, боолын хөдлөлмөр эрхлүүлэх зэрэг гэмт хэргийн золиос болсоор байгааг дурдалгүй өнгөрч болмооргүй байна. Манай улсад үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэрэг нь бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, захиалгат гэрлэлт гэсэн хэлбэр, төрөлтэй байна. Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-аас явуулсан судалгаагаар сүүлийн 3 жилд 131 (жилд дунджаар 40 гаруй иргэд энэ төрлийн гэмт хэргийн золиос болдог байна) иргэн бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр хүн худалдаалах гэмт хэрэгт өртдөг гэсэн дүн гарчээ. Зөвхөн 2008 онд 300 гаруй гэмт хэрэг бүртгэгдэж, шалгагдсан ч үүнийг бодитой тоо гэж үзэхэд төвөгтэй гэдгийг судлаачид тэмдэглэжээ. Бүртгэгдсэн гэмт хэргийн байдалд шинжилгээ хийж үзэхэд хохирсон нийт хүмүүсийн 30% нь 18-21, 20% нь 21-26, 11% нь насанд хүрээгүй охидууд байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна. 2010 онд Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас Улаанбаатар хотын хэд хэдэн дүүргүүдийг хамруулан хийсэн судалгаагаар¹⁶ 40 гаруй хүүхэд бэлгийн мөлжлөгт өртсөн болохыг тогтоожээ. Тэдний бараг 80 шахам хувь Сүхбаатар, 16% Баянзүрх, 5 орчим хувь Баянзүрх дүүрэгт ногдож байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг насны ангиллаар авч үзвэл нийт хохирсон хүүхдийн 95,3% нь 17, 4,7% нь 15 настай охидууд байна. Судалгаанд хамрагдсан бэлгийн мөлжлөгт өртсөн охидуудын 4,7% нь 14 настайдаа, 95,3% нь 16 настайдаа бэлгийн мөлжлөгийн хохирогч болсныг тогтоожээ. Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн ихэнх нь санхүүгийн бэрхшээлээс болж сургуулиас завсардсан, одоогоор ямар нэгэн албан бус сургалтад хамрагдаагүй гэсэн хариултыг өгчээ.

Мөн судалгаагаар бэлгийн мөлжлөгт өртсөн арван хүүхдийн тав нь мөнгө олох, хоёр нь бусдад тавьсан өрөө төлөх, хоёр нь гэр бүлээ тэжээхээр бэлгийн мөлжлөгт орсон гэж хариулжээ. Бэлгийн мөлжлөгт өртсөн охид өөрсдийгөө хүн худалдаалах гэмт хэргийн

золиос болж байгаа гэдгээ мэддэггүй, тэдний 80 гаруй хувь нь гадаадад гарах саналыг дуртайяа хүлээж авна гэж хариулсан нь хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэргийн золиос болох магадлал ихээхэн өндөр байгааг харуулж байна.

Манай улсад хүн худалдаалах гэмт хэрэг үүсч буй суурь шалтгаан нь нийгэмд бугшсан ядуурал, ажилгүйдэл билээ. Түүнчлэн, манай улсын эдийн засгийн тогтворгүй байдал, хөрш зэргэлдээ орнуудын нөхцөл байдал, монгол охид, эмэгтэйчүүдийн гадаадын иргэдтэй гэр бүл болох сонирхол, хэвлэл мэдээллийн сөрөг нөлөөлөл /садар самууныг сурталчлах явдал газар авсан, Зар сурталчилгааны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, түүнийг зөрчсөн зар сурталчилгаа нэвтрүүлдэг/ зэрэг олон шалтгааныг нэрлэж байна¹⁷. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх бас нэг шалтгаан нөхцөл нь иргэдийн боловсролын түвшин, хүн амын давхарга дахь тэгш бус байдал, хүн худалдаалах гэмт хэргийн тухай иргэдийн мэдлэг сул дорой, гадагшаа чиглэсэн ажиллах хүчний урсгал, түүний зохицуулалт хангалтгүйтэй холбоотой байна.

Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг олон улсын гэрээнүүдэд нэгдэн орж, тухайн гэмт хэргийн эсрэг тууштай тэмцэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээж байгаа билээ. Энэ нь тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, дэлхийн бусад улс орнуудад хамтран ажиллах таатай боломжийг бүрдүүлж байгаа давуу талтай юм. АНУ-ын Төрийн Департаментаас 2010 онд эрхлэн гаргасан илтгэлд дурдсаны дагуу манай улс хүн худалдаалах гэмт хэрэгт ихээхэн өртдөг, хүнээ худалдах эх үүсвэр болдог орон гэсэн ангилалд хамрагджээ.

Хүн худалдаалах гэмт хэрэг бодитойгоор оршин тогтнож буй өнөөгийн нөхцөлд түүний хууль эрхзүйн орчин, тогтолцоо ямар байгааг өнгөц харья. Манай улсын хувьд дээр дурдсан гэмт хэрэгтэй тэмцэх талаар туршлага дутмаг ч хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зарим алхмуудыг хийж байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй

¹⁶ Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, 2010. "Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа 2010, Улаанбаатар хот

¹⁷ НХХЯ, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн дээд сургууль, НҮБ-ын Хүүхдийн сан, 2009. "Хүн худалдаалах гэмт хэрэг" Суралцагсдын гарын авлага, Улаанбаатар хот

тэмцэх хууль эрхзүйн зохицуулалтыг 2000 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн асуудлыг Эрүүгийн хуулиар тодорхойлон зохицуулж, улмаар Хүн худалдаалах болон эмэгтэйчүүд, хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашиглах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, хөтөлбөр зэргийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Өнөөгийн дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн дагуу хүн худалдаалах гэмт хэргийг хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд багтааж, ногдуулах ял шийтгэлийг тодорхойлжээ. Уг хуулийн 113 дугаар зүйлийн 1-д “ашиг олох, мөлжих зорилгоор худалдаалах, хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, хууран мэхэлсэн, эмзэг байдлыг нь далимдуулсан, түүнчлэн бусдыг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан, хүлээн авсан” үйлдлийг хүндэвтэр гэмт хэрэгт тооцож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нугалж торгох, эсвэл 5 жил хүртэл хорих, 113-ын 2-т “энэ хэргийг насанд хүрээгүй, хүнийг, 2, түүнээс олон хүнийг, хулгайлах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эрхшээлдээ байгаа хүнийг, давтан бүлэглэж, буюу урьдчилан тохиролцсон бүлэг үйлдсэн бол” хүнд гэмт хэрэгт тооцож, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нугалж торгох, 5-10 жил хорих, 113-ын 3-т “хүнийг хил давуулан худалдсан, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол” онц хүнд гэмт хэрэгт тооцож, 10-15 жил хорих ял шийтгэнэ гэж заажээ.

“Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний халдашгүй чөлөөтэй байх, боолчлол, хүчирхийллээс ангид байх суурь эрхэд халдаж, хүнийг бараа, таваар мэтээр зарж ашиг хонжоо олох гэсэн онц ноцтой хэрэг атал түүнийг хүндэвтэр гэмт хэргийн ангилалд багтааж байгаа нь зохимжгүй, энэ гэмт хэргийг хүнд, онц хүнд гэмт хэргийн ангилалд багтаах, түүнчлэн хорих ял оноохоор хуульчлах” шаардлагатайг Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн Ж.Дашдорж “Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгөөс урьдчилсан сэргийлэх, тэмцэхэд хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь” сэдэвт нийтлэлдээ тэмдэглэсэн байна. Тэрээр цааш нь өнөөгийн дагаж мөрдөж байгаа Эрүүгийн хуулийн зүйл, заалтыг дараах байдлаар өөрчилж, боловсронгуй болгох саналыг дэвшүүлэн тавьсан байна:

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл. Хүн худалдаалах

113.1. Хүнийг мөлжих буюу ашиг олох зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх, хүч хэрэглэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрхмэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүлөөр этгээдийг хяналтандаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, буюу хахуульдах зэрэг аргаар элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

113.2. Хэргийг дараах нөхцөл байдалтайгаар үйлдсэн бол:

113.2.1. насанд хүрээгүй хүнийг худалдаалсан,

113.2.2. хулгайлах замаар худалдаалсан,

113.2.3. хил давуулан худалдаалсан,

113.2.4. эрх мэдлээ ашиглах буюу эрхшээлдээ байгааг нь далимдуулж хүнийг худалдаалсан,

113.2.5. бүлэглэж буюу урьдчилан тохирсон бүлэг үйлдсэн,

113.2.6. 2 буюу түүнээс олон хүнийг худалдаалсан бол таваас дээш 10 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

113.3. Энэ гэмт хэргийг давтан эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас хүний амь хохирсон, хүнд гэмтэл учирсан бол арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай Палермогийн протоколд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн хувийн амьдралыг болон бие хүний хувьд тухайн хэргийн шүүн таслах ажиллагааг нууцлах замаар дотоодын хууль тогтоомжоор байж болох хэмжээнд хамгаална. Хохирогчдын бие бялдар, сэтгэл зүй, нийгэмд эзлэх байр суурийг нь нөхөн сэргээх арга хэмжээг тухайлбал орон байраар хангах, ойлгогдох хэлээр эрхийн талаар нь мэдээлэл өгөх, эмнэлгийн болон сэтгэл зүйн материаллаг туслалцаа үзүүлэх, хөдөлмөрлөх, боловсрол эзэмших, суралцах бололцоогоор хангах, нөхөн төлбөр авах боломж олгох хууль зүйн тогтолцоог бий болгоно” гэж заажээ.

Манай Улсад дагаж мөрдөж буй Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хууль тогтоомжид дээр дурдсан зохицуулалт, тухайлбал хохирогчдын хувийн нууцлалыг

хамгаалах, тэдэнд нийгмийн үйлчилгээ үзүүлэх, эрхийг нь хангах талаар ямар нэгэн тодорхой зүйл, заалт байхгүй байгааг ХЭҮК-ын гишүүн Дашдорж тэмдэглэсэн байна. Иймээс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль эрхзүйн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд манай монгол эмэгтэйчүүд гадаадын иргэдтэй гэр бүл болох явдал нилээд нийтлэг болж байна. Гадаадын иргэдтэй гэр бүл бологчдын 90 гаруй хувийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд сүүлийн 10 жилийн дотор гадаадын иргэдтэй гэрлэсэн гэрлэлт 21 дахин нэмэгджээ. Тэдний ихэнх нь Солонгос хүнтэй гэр бүл болсон байна¹⁸.

Монгол хүмүүс гол төлөв зуучлах товчоо, гэр бүл зуучлал нэртэй компани, хэн нэгэн хүний тусламж дэмжлэгтэйгээр гадаадын иргэдтэй гэр бүл болдог болохыг судалгаагаар тогтоосон байна. Гэтэл энэ нь зарим талаар хүүхэд, эмэгтэйчүүдийг хүн худалдаалах гэмт хэргийн золиос болоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг болж байх талтай. Гэтэл манай улсад дагаж мөрдөж буй хууль эрхзүйн актуудыг судалж үзэхэд манай иргэдийг гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрсөн хуулийн зохицуулалт байхгүй байна.

Нөгөө талаар энэ үйлчилгээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтийн хүртээл болгож байгаа нь ихээхэн ноцтой үйлдэл болж, улмаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд шууд бус, санамсаргүй байдлаар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэхэд “таатай” хөрсийг бүрдүүлж өгөөд байна. Тиймээс манай хэвлэл мэдээллийн байгууллагууд энэ асуудалд нухацтай хандаж, хүний эрхийг хөсөрдүүлэхэд чиглэгдсэн үйлдэлд оролцохоос өөрсдийгөө хамгаалах нь чухал юм.

Зуучлах нэрийдлээр хүний эрхийг зөрчиж, ашиг хонжоо хайгчдын үйлдлийг таслан зогсооход нэн даруй анхаарах шаардлагатай байна. Нөгөө талаар гадаадын иргэдтэй гэр бүл болсон монгол хүний хувь заяа ямар байгаа талаар нарийвчилсан судалгаа явуулах, шаардлагатай тохиолдолд тэдний

эрх ашгийг хамгаалахад төрийн зүгээс онцлон анхаарах нь чухал байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгт нөлөөлж буй нөгөө нэг хүчин зүйл бол хууль бус зар сурталчилгааны үйлдэл юм. Манай улсад төрөл бүрийн сувгаар олон янзын зар явдагийг бид мэднэ. Түүний дотор гадаадад өндөр цалинтай ажилд оруулна, энэ, тэр улсын виз гаргана, гадаадад суралцуулна гэсэн зарын дагуу хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгддэг болохыг судалгааны байгууллагууд тогтоосон байна. Энэ харилцааг зохицуулдаг манай улсын “Зар сурталчилгааны хууль”-иар хууль бус зар сурталчилгааг хориглосон зүйл заалт, хууль бус зар сурталчилгаа хийсэн байгууллага, иргэдэд ногдуулах хариуцлага байхгүй байгааг хянан үзэж боловсронгуй болгох шаардлагатай байна.

Хүүхдийг, ялангуяа хараа хяналтгүй хүүхдийг гэмт хэрэг, нэн ялангуяа хүн худалдаалах гэмт хэргээс хамгаалахын тулд холбогдох хуулийн зүйл заалтуудыг эргэн нягталж боловсронгуй болгох шаардлагатай байгааг өнөөгийн амьдрал биднээс зүй ёсоор шаардаж байна.

Манай улсад Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийг 2005 оноос батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Хөтөлбөр батлах тухай 234 дүгээр тогтоолд “Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих зөвлөл байгуулан ажиллуулж хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, Монгол Улсын сайд Д.Дорлигжав нарт үүрэг болгосугай” гэсэн заалт оржээ. Өнөөгийн байдлаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 10 дугаар сарын 9-ны өдрийн 141 тоот тушаалаар батлагдсан “Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаадах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, зохицуулах орон тооны бус зөвлөл”, “Техникийн ажлын хэсэг” тус тус ажилладаг байна. Зөвлөлийг НХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга тэргүүлдэг бол Техникийн ажлын

¹⁸ Ж.Дашдорж, 2009. “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрхзүйн орчинг сайжруулах, бие даасан хууль гаргах хэрэгцээ” Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлье. Илтгэлүүдийн эмхтгэл Улаанбаатар хот

хэсгийг мөн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын орлогч дарга удирддаг байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус, олон улсын хандивлагч байгууллагуудын төлөөлөл багтаж байна. “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, зохицуулах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-д зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж, хэлэлцэж буй асуудлыг зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, зөвлөлөөс Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал хэлбэрээр шийдвэр, мөн зөвлөмж гаргаж болох тухай заажээ.

Саяхан Улсын мөрдөн байцаах газарт Хүн худалдаалах болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тасгийг байгуулан ажиллуулж байгаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байсан.

Эндээс манай улс хүн худалдаалахтай тэмцэхэд чиглэгдсэн хөтөлбөртэй, түүний үйл ажиллагааг зохицуулах тогтолцоотой болох нь харагдаж байна. Гэсэн хэдий ч энэ гэмт хэргийн өсөн нэмэгдэж буй цар хүрээ /бусад улс оронтой харьцуулахад манай тохиолдол цөөн хэдий ч хүн амын тоотой харьцуулбал анхаарахгүй байх аргагүй/, нарийсч буй үйлдлийг авч үзвэл хийж буй ажлаа эргэн харж, боловсронгуй болгох шаардлага юу юунаас илүү чухал байна. Товчхондоо манай улсад бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрээр боолын хөдөлмөр “цэцэглэн” хөгжөөд эхэлжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Үүнд дотоод хүчин зүйлээс гадна гадаад тухайлбал хүн худалдаалах гэмт хэргийн гаралтаар дээгүүрт ордог хоёр хөрш, өмнөд хөрш рүү визгүй зорчдог зэрэг нь эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна. Ялангуяа, өмнөд хөрш рүү бизгүй зорчдог байдал энэ улсаар дамжин гэмт хэргийн үүр уурхай болсон цаашаа Макао, Гонгконг зэрэг Азийн бусад орнуудад худалдагдах үүд хаалгыг нээж байна.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарах зарим асуудлууд

Үндэсний засгийн газруудын төдийгүй Олон улсын хамтын нийгэмлэгүүдийн санааг зовоосон асуудлын нэг бол хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах явдал юм. Хүн худалдах нь ашиг орлогын хувьд

мансууруулах бодис, зэвсгийн наймааны дараа орох “хар” бизнес болж буйг судалгааны дүн харуулж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгийн оновчтой арга бол иргэдээ өөрийн эх орондоо аятай тухтай, ажил орлоготой амьдрах нөхцөл бололцоогоор хангах явдал гэдэг нь ойлгомжтой. Тиймээс нийгэм дэх ядуурал, ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэхэд онцлон анхаарч, эрчимжүүлэх хэрэгтэй.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь нэг талаас улс үндэстэн дамнасан, нөгөө талаас нууцаар зохион байгуулалттай үйлдэгддэг учраас түүнээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мөрдөн шалгах, хохирогчдыг хамгаалж, эх оронд нь буцаах зэрэг нь нэг улсын хүрээнд шийдвэрлэхэд ихээхэн төвөгтэй асуудал юм. Энэ үйлдэлд бусад улс оронтой хамтран ажиллах шаардлага зайлшгүй гардаг. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх талаар олон улсын хамтын нийгэмлэг ихээхэн хүчин чармайлт тавьж байна. Хамтын ажиллагааны чиглэлээр НҮБ зэрэг олон улсын байгууллага, бүс нутаг, түүнчлэн хоёр улсын түвшинд тус тус үйл ажиллагаа явуулах нь үр дүнтэй гэж үзэж байна.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төр засаг төдийгүй хувь хүмүүс онцгой чухал үүрэг гүйцэтгэнэ. Төрийн болон төрийн бус байгууллагууд хүн худалдаалах гэмт хэрэг гарч буй нөхцөл, шалтгааныг арилгах, таслан зогсоох, ийм төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, учирсан хохирлыг барагдуулах, хохирогчид, тэдний эрхийг хамгаалахад туйлын чухал үүрэг гүйцэтгэх болно. Түүнчлэн иргэд, олон нийтэд хүн худалдаалах гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах, сэтгэл зүйг төлөвшүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

Дурдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд одоогийн дагаж мөрдөж буй хууль эрхийн актуудад дүн шинжилгээ хийж, өөр хоорондоо зөрчилтэй байгаа хуулийн зүйл заалтуудыг шинэчлэн боловсронгуй болгох, түүний хэрэгжилтийг хангах шаардлагатай.

Хүний аюулгүй байдал, ялангуяа хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын хүчин чармайлтыг нэгтгэн зангидаж, хөрөнгө нөөцийг төвлөрүүлэн оновчтой хуваарилах, ажил үүргийн давхардлыг арилгахад чиглэгдсэн

оновчтой тогтолцоотой байх нь нэн тустай.

Хохирогчдыг нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд шинэ төрлийн мэдлэг, мэргэжил биднээс шаардаж байна. Үүнтэй уялдуулан нийгмийн ажилтныг энэ чиглэлээр бэлтгэх, мэргэшүүлэх шаардлага амьдралаас урган гарч байна.

Судалгаанаас харахад төрийн болон төрийн бус байгууллагууд цагдаа, шүүх, прокурор зэрэг хүчний байгууллагуудтай хамтран ажиллах эхлэл байна. Хамтын ажиллагааг дан ганц энэ гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар хязгаарлах бус түүнд нөлөөлж буй шалтгаан нөхцөл, түүнийг арилгах арга зам, гэмт хэрэг үйлдэгчийн уг шалтгаан, арга барил, хохирогчдын байдал зэргийг цогцоор авч үзэх, шаардлагатай тохиолдолд судалгаа, шинжилгээний байгууллагуудыг татан оролцуулж, онол-практикийн хавсарсан судалгаа хийх зэрэг асуудлыг ч анхаарч үзэх нь зүйтэй болов уу.

Дүгнэлт, санал

Манай улсад тохиолдож буй хүн худалдаалах гэмт хэрэг тооны хувьд төдийлэн олон биш, нөгөө талаар хувь хүний хэрэг гэж үзэж болмоор ч хувь хүнд төдийгүй нийгэмд асар их хор хохиролтой энэхүү гэмт хэргийг анхаарлын гадна орхих боломжгүй. Ялангуяа хүн, хүний эрхийг дээдэлдэг манай улсын хувьд онцлон авч үзэх шаардлагатай байна.

Анхаарлын гадна орхихгүй байгаагийн нэг баталгаа нь саяхан Монгол Улсын Их Хурлаас шинэчлэн баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд иргэдийг үндэстэн дамнасан гэмт хэргээс хамгаалах тухай тусгай хэсэг оруулж өгсөн явдал бөгөөд улмаар хүний аюулгүй байдал, цаашилбал улс үндэснийхээ аюулгүй байдлыг бодит утгаар нь хангахад чиглэгдсэн чухал арга хэмжээ гэж үзэж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн суурь шалтгаан болж, манай нийгэмд амь бөхтэй бугшаад буй хүн амын ядуурал, ажилгүйдлийг устгах асуудалд шинэ өнцгөөс, шинэ арга барилаар хандаж, түүнийг эдийн засаг, нийгэм төрийн аюулгүй байдлын асуудалтай уялдуулан цогцоор авч үзэж, ядуурал, ажилгүйдэлд өртсөн хүн бүрт хүрсэн ажил, арга хэмжээг оновчтой удирдлагаар хангаж, цогцоор хэрэгжүүлэх шаардлагатай байгааг өнөөгийн бидний бодит амьдрал зүй ёсоор

шаардаж байна.

Монгол Улс Палермогийн протоколд нэгдэн орж, түүний зүйл, заалтыг мөрдөж ажиллах үүрэг хүлээсэн, нөгөө талаас Монгол Улсын Их хурлаас 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон эрхзүйн орчныг боловсронгуй болгож...” гэж заасны дагуу хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хуулийг цаг алдалгүй, яаралтай боловсруулан мөрдөх шаардлага давын өмнө тулгарч байна.

Түүнчлэн одоогийн дагаж мөрдөж буй хууль эрхийн актуудад нарийвчилсан дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох, өөр хооронд нь нягт уялдуулах, ойлголтуудыг жигдлэх, зайлшгүй шаардлагатай зүйл, заалтуудыг нэмэлтээр оруулах зэрэг ажлыг хойшлуулалгүйгээр хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ингэснээр гэмт хэрэгтнүүдэд “хуулийн цоорхой” ашиглах боломж олгохгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хохирогчдыг хамгаалахад чиглэгдсэн төрийн нэгдсэн бодлогыг зангиддаг, ололт дутагдлыг тодорхойлон чиглэл удирдамжаар хангадаг, санхүүгийн дэмжлэг тусалцааг оновчтой хуваарилан зарцуулдаг, байгууллага хоорондын ажил үүргийн давхардлыг зохицуулдаг, мэргэжилтэй боловсон хүчнийг системтэйгээр бэлтгэх, хоёр болон олон талт хамтын ажиллагааг уялдуулан зохицуулдаг цомхон, чадварлаг, мэргэшсэн байгууллагатай байхыг амьдрал шаардаж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг Монгол Улсад гарч буй шалтгаан, нөхцөлийг сайтар судлан, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн оролцоог хангах, тэдний хамтын ажиллагааг өрнүүлэх, урамшууллын болон нууцлалын тодорхой механизмыг бүрдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээг эрчимжүүлэх нь зүйтэй.

Иргэдийн төдийгүй мэргэжлийн байгууллагуудын дунд хүн худалдаалах гэмт хэрэг, түүний хор уршгийн тухай нэгдсэн

ойлголтыг бий болгох, төлөвшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нэгэнт золиос болсон тохиолдолд хохирогчдод эрхээ хэрхэн хамгаалах талаар мэдлэг эзэмшүүлэхэд онцлон анхаарах шаардлагатай байна. Ялангуяа хохирогчдыг хамгаалах, тэднийг нийгэмшүүлэхэд биднээс шинэ арга барил, шинэ ур чадвар шаардаж байна. Энэ

ажлын хүрээнд боловсон хүчнийг бэлтгэх, хохирогчдыг хамгаалах асуудлыг цогцоор шийдэх хэрэгцээ бий болоод байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг хил дамжин үйлдэгддэгтэй уялдуулан гадаадын улс орнууд, эхний ээлжинд Монголын иргэд хүн худалдаалах гэмт хэргийн золиос болж буй

гадаадын орнуудтай энэ чиглэлээр хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулахад шуурхай анхаарч, ажил хэрэг болгох нь зүйтэй.

Ашигласан материал

АНУ-ын Азийн сан, Хүний эрх хөгжил төв, USAID, АНУ-ын Төрийн Департамент “Монгол Улсад хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь: асуудал ба арга зам” Combating human trafficking in Mongolia: issues and opportunities Улаанбаатар 2005

БСШУЯ, Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага, Хүний аюулгүй байдлын судалгааны төв “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлье” Илтгэлүүдийн эмхтгэл, Улаанбаатар хот, 2009

БСШУЯ, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага “Хүн худалдаалах гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх нь” Улаанбаатар хот, 2009

Д.Ариунаа “Монгол охинтой гэрлэсэн хятад залуу төрүүлсэн үрийг нь хөнөөжээ” Зууны мэдээ 2010.8.11 №191 (3569)

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс “Хүний эрх” улирал тутмын сэтгүүл 2009/1

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс “Хүний эрх” улирал тутмын сэтгүүл 2009/2

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, Олон улсын хөдөлмөрийн байгууллага “Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа” Улаанбаатар хот, 2010

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хэвлэгдээгүй хувь

М.Сугар-Эрдэнэ “Монголын Засгийн газар хүний худалдаатай тэмцдэггүй” Өнөөдөр, 2010.06.24 Пүрэв, №147 (4010)

НХХЯ, Хүйсийн тэгш эрхийн төв, Цагдаагийн академи, Хилийн цэргийн Дээд сургууль, НҮБ-ын Хүний эрхийн Үндэсний комисс, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх нь” Илтгэлийн эмхтгэл Говийн бүсийн сургалт, зөвлөгөөн, Дорноговь аймаг, Замын –Үүд сум, 2009 оны 5 сарын 7, 8 өдөр Хүүхдийн сан “Хүн худалдаалах гэмт хэрэг, Суралцагсдын гарын авлага 2009

Хүний эрх хөгжил төв, Америкийн өмгөөлөгчдийн холбоо, АНУ-ын Төрийн департамент, Хууль зүйн Үндэсний хүрээлэн Хүн худалдаалах гэмт хэрэг” Эрхзүйн баримт бичгийн эмхтгэл Улаанбаатар хот 2010

Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөр, хэвлэгдээгүй хувь

Т.Цогзолмаа “Югославын иргэн манайд анх хүн худалдаалах гэмт хэргээр шийтгэгдсэн” Үндэсний шуудан, 2010.8.10 №189 (903)

Trafficking in Persons Report 2010 Office to Monitor and Combat Trafficking in Persons, US State Department

Erika Schlappi, Christina Hausammann, Undarya Tumursukh SDC funded project on “Combating Human Trafficking in Mongolia” Mid Term Review Report Bern/Ulaanbaatar 18-9-2009

http://en.wikipedia.org/w/index.php?title=Human_Trafficking

www.news.mn Ж.Батсайхан, Б.Ууганбаяр “Хүний наймааны үүдтэй Монгол” 2010.3.22

www.TOPNEWS.mn Д.Гэрэл “Германд нугарахаар явсан Б.Ганчулуун охин сураггүй алга болжээ”. 2010.08.13